

Орх бүхний пролетариат нар нэгдэгтүн! АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 40 (2304) 1974 оны 5 дугаар сарын 23 ПҮРЭВ

ҮНДЭСНИЙ БАНКНЫ 50 ЖИЛ

1921 онд ялсан ардын хувьсгалын дараа МАХН, ардын засгийн газар 1924 оны 6 дугаар сарын 2-нд ЗХУ-ын хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкыг байгуулж ажилдуулсан нь тус орны мөнгөний гүйцэтгэх эмх цэгцтэй болгох, гадаадын капиталыг өөрийн орны зах зээлээс шахан гаргах, эдийн засгийн бэхжүүлэхэд нийдвэрлэх ач холбогдолтой болсон юм.

Монголын худалдаа аж үйлдвэрийн банк нь ХАА, үйлдвэрийг хөгжүүлэх, худалдаа өрнүүлэхэд туслах, мөнгөний гүйцэтгэх эмх цэгцлэх зорилгыг удирдлага болгон ажиллаж албан газар байгууллагын хөрөнгийг төвлөрүүлэн хадгалах, өөрийн үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, харилцах данс нээх, гадаад орнуудын валютыг худалдан авах, бараа танаар барилцаалт зээл олгох, зээлийн байдалд ажиглалт хийж нөлөөлөх шалтгааныг арилган сайжруулах зэрэг арга хэмжээнүүдийг идэвхтэй явуулж эхэлсэн байна.

Нам, засгааг удаа дараа авсан арга хэмжээний дүнд мөнгөн зээлийн системийн цаашидын хөгжилт бэхжилт нь улс ардын аж ахуйд банк ба зээлийн ролыг улам өсгөн нэмэгдүүлэх, зээл тооцооны ажиглагааг өргөжүүлэн сайжруулах, мөнгөний гүйцэтгэх бэхжүүлэх, бүртгэл гүйцэтгэх кассын ажлыг нарийсган цэгцлэх замаар явагдаж улс ардын аж ахуйн хөгжилд чухал үүргийг гүйцэтгэх болдоо.

Мөнгө-зээлийн системийг бүрэлдүүлэн тогтоох, бэхжүүлэх талаар нам, засгааг байнгын анхаарал тавьж, удаа дараа авч явуулсан арга хэмжээний үрээр үндэсний банкнаас улс ардын аж ахуйн хөгжилтөнд гүйцэтгэх роль үүрэг нэмэгдэж хяналтын хүрээ өргөжин, тус орны урт, богино хугацаатай зээл, хөрөнгө оруулалтын санхүүжилт, гадаад, дотоодын тооцоо, мөнгөн гүйцэтгэх, кассын ажиглагааг өргөжүүлж явуулж хяналт тавих нэгдсэн төв болсон юм.

Монголын худалдаа аж үйлдвэрийн банк нь анх Зөвлөлт—Монголын хувь нийлүүлсэн хөрөнгөөр байгуулагдсан бөгөөд 1954 онд ЗХУ-аас өөрийн хувь хөрөнгийг эрхийг Монголын талд шилжүүлснээр тус банк БНМАУ-ын банк болсон билээ.

Мөнгө-зээлийн системийн төв болсон улсын банкны олон талын ажлын хүрээ өргөжихийн хамт зохион байгуулалтын хувьд өсөж бэхжлээ.

Тус аймаг дахь банкны хэлтэс 1942 оны 3 дугаар сард анх байгуулагдахдаа 3 эсгий гэр, 10-аад орон тоотой, анхны жилдээ 85,7 мянган төгрөгийн балансын гүйцэтгэх хийж, улс хоршооллын 20 гаруй байгууллагатай харилцаж байсан бол одоо аймгийн хэмжээний ХАА, үйлдвэр, худалдаа, улс хоршооллын 150 гаруй байгууллагатай харилцаж, аймгийн улс ардын аж ахуйн бүртгэл, гүйцэтгэх, зээл, тооцоо, хөрөнгө оруулалт, кассын ажиглагааг явуулах төв боллоо хөгжив.

Мөн зохион байгуулалтын талаар улам бэхжиж томоохон сум, САА-н дэргэд 10 шахам тооцооны касс, аймгийн төвд оройн кастай болов.

Эдгээрт ажиллаж байгаа мэргэжилтэй боловсон хүчний тоо 5 дахин өсч, балансын нийт гүйцэтгэх 1,4 миллиард төгрөгт хүрээд байна.

Аймгийн банкны хэлтсийн хамт олон БНМАУ-д үндэсний банк байгуулагдсаны 50 жилийн ой угтаж, 1974 оны эхний 4 сарын төлөвлөгөөт зорилтуудаа амжилттай биелүүллээ.

Тус орны эдийн засгийн хурдацыг хангаж нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд аж ахуйн эдийн засгийн аргаар удирдах, удирдлагын гол арга болсон банкнаас төгрөгөөр тавих хяналт шалтгыг цаашид улам сайжруулах явдал банкны амжилтан нарын хойшлуулсгүй үүрэг мөн.

ҮР СУУЛГАЖ ДУУСЛАА

Эрдэнэсантын тэжээлийн аж ахуйнхан улаан-уудай 7142, арвай 4683, овъёос 2007, бүгд 13832 а-д үр тариалах төлөвлөгөөг 100,1 хувиар биелүүллээ.

ПҮРЭВ

ШАГНАЛ ГАРДУУЛАВ

БНМАУ-ын гавьяат багш Гомбын Сүрэнд шагнал гардуулах ёслол Баянчандмань сумын төвд боллоо.

Цуглааныг сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Балдандорж нээж уул шагналыг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны хариуцлагатай нарийн бичгийн дарга Г. Шарав гардууллаа.

Дараа нь аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны Ардын боловсролын хэлтсийн дарга Т. Гаваа улсын болон аймгийн тэргүүний багш нарын зөвлөлгөөнийг хөдөлмөр сурлагын өндөр амжилтаар угтахыг цуглаанд оролцогчдод уриаллаа.

Т. ДАШНЯМ

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРАЛ УГТСАН ХӨДӨЛМӨРИЙН ЭЭЛЖИНД

Аймгийн намын ээлжит XVI бага хурал угтсан хөдөлмөрийн ээлжинд тус аймгийн үйлдвэр аж ахуйн газрууд арчинтай орж сайхан амжилт олж байна.

Аймгийн НААУГ дүгээр сарын нийт бүтээгдэхүүний төлөвлөгөөг 113,8 хувь, нийтийн аж ахуйн орлогыг 128,9 хувиар биелүүлсэн байна.

Цаашид ажлын бүх салбар хэсэгт дотоод нөөц бололцоог илрүүлэн ашиглах, хөдөлмөрийг аль болох механикжуулах, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг бүрэн ашиглах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх,

хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зөв зохион байгуулж ажиллах, үйлчилгээнд шинэ дэвшилттэй зүйл нэвтрүүлэх, хувь хүний санаачилга идэвхийг өрнүүлэн ажиллах зорилт тавьж байна.

Д. ХИШИГЧУЛУУН

Кино театрын хамт олон энэ оны эхний улирлын төлөвлөгөөг 129,9 хувиар биелүүлсний дотор үзэгчдийн төлөвлөгөөг 23—43,4 хувиар давуулан биелүүлж сайхан амжилт гаргажээ.

Д. НЭРГҮЙ

Баяндэлгэр сумын 8 жилийн дунд сургууль аймгийн намын бага хурлын нэрэмжит хөдөлмөрийн өндөр бүтээлийн цуваа зохиож 1974—1975 оны хичээлийн жилийн түлш бэлтгэх багш сурагчдын 5 бригад ажиллуулж 400 куб мод бэлтгэж 4000 төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

Энэ ажилд багш Баасан, Долгор, Буджав, сурагч Амар, Мянганбаир, Жанцан нарын олон багш сурагчид өдөр бүрийн нормоо 180—200 хувиар биелүүлж хамт олноо хошуучлав.

Н. МАЖИГСҮРЭН

Залалж үеийнхэндээ зориулж 12 МЯНГАН ТӨГРӨГ

Нам засгааг эх орныхоо жавхлант ирээдүй болсон үр хүүхдийн төлөө авч явуулж байгаа байнгын анхаарал халамжийн нэг нь хүүхдийн төлөө фонд бий болгосон явдал юм.

Энэхүү шийдвэрийг манай орны хөдөлмөрчид баартай хүлээн авч хүүхдийн төлөө фондод жил бүр хөрөнгө хуримтлуулах хөдөлгөөн уламжлал болон өрнөж байна.

Тус аймгийн төв, хөдөөгийн олон зуун ажилчид, хөдөлмөрчид, өнгөргөч Нам гаригийг хүүхдийн төлөө фондод хувь нэмэрлэх ажлын өдөр болгон явууллаа.

Энэ өдөр аймгийн Усны аж ахуйн гарааныг барилга дээр бригадаараа ажиллаж байгаа аймгийн 5 удаагийн аварга барилгачин, нэгдсэн бригадын дарга Д. Намсрайтай уулзахад:

—Бид залгамж хойч үеийнхнийхээ сайн сайхны төлөө зориулах мөнгөн санд өөрсдийн нэгдэрийн цалингаа зориулахаар ажиллаж байна.

Ингэхдээ манай барилгачид ерийн өдрийнхөөсөө улам давуу бүтээл гаргах зорилготой ажлаа нарийн зохион байгуулсан юм гэж ярилаа.

Бас Барилга угсралтын конторын ажилтнууд өөрийн шөф Дэлгэрхаан суманд тэжээл эмчилгээний цэг барьж дуусган, нийт

барилгачид өндөр бүтээлтэй ажилласны үрээр энэ өдрийн цалин—4200 төгрөгийг хүүхдийн төлөө фондод шилжүүлж хяналтыг 1000 гаруй төгрөгөөр давууллаа.

Мөн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын хэмжээгээр 220 гаруй хүн 16 мянган төгрөгийн үйлдвэрлэл, үйлчилгээний ажил хийсэн хөдөлмөрийнхөө хөлс 3000 төгрөгийг, Зуунмод Хотын худалдааны трестийнхэн 600 гаруй төгрөгийг, Хүнсний комбинатынхэн 1500 төгрөгийг, Зам ашиглалтын ангийн хамт олон 900 төгрөгийг хүүхдийн төлөө фондод хандив болголоо.

«Анхдугаар таван жил» сонины СХ-ийн үйлдвэрийн хамт олон өндөр бүтээлтэй ажиллаж 600 төгрөгийг тус фондод шилжүүлэв.

Сэргэлэн сумын «Авдархангай» нэгдлийн төмрийнхэн энэ өдөр уурын зуухны засвар хийлээ.

Зөвхөн энд ажилласан 8 хүн тус бүр 150 төгрөгийн ажил хийсний дотор тракторчин Баяраа, клубийн эрхлэгч Жамъян, автын механикч Лувсан-жамбаа нар онц идэвхтэй ажиллав.

Ийнхүү хүүхдийн төлөө фондод хөрөнгө хуримтлуулах ажил амжилттай явагдаж байна.

Ш. ЦЭРЭНДОО

Залуу зохиолчдын уулзалт

Саяхан УБ төмөр замын залуу зохиолчдын дугуйлангийнхан Зуунмод хотод ирж тус аймгийн залуу зохиолчдын дугуйлангийн ажил байдалтай танилцаж харилцан туршлагаа солилцох уулзалт хийлээ.

Уулзалт дээр энэ онд болох улсын залуу уран бүтээлчдийн зөвлөлгөөнийг угтан тус хоёр дугуйлан зохиож байгаа ажлынхаа туршлагыг харилцан ярилцаж, залуу зохиолчид шинээр туурвиж буй уран бүтээлээсээ уншиж зөвлөлдлөө.

Манай сурвалжлагч

СПАРТАНАД

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны эмэгтэйчүүдийн 100, 200, 400 метрийн гүйлт, бөөрөнцөг, зээрэнцэг түлхэх, шидэх, гар бөмбөг, оле татагч, короткий цохих чөлөөт тоглолт болов.

Бүх төрлийн гүйлтэнд тамирчин Бямбажав, Даваа, Милмаржав нар 1, 2, 3 дугаар байр эзлэв.

Эмэгтэйчүүдийн гар бөмбөгийн тэмцээнд Чимэд-балдар ахлагчтай баг түрүүлэв.

Бөөрөнцөг түлхэлт, зээрэнцэг шидэлтэнд Баянзул 6 метр 95 см, Намсалаа 15 метр 90 см шидэж тэргүүн байр эзлэв.

Л. ЛУСМАА

БНМАУ-ын Банк байгуулагдсаны 50 жилийн ойд

СХ-ийн хамт олон болно

Аймгийн банкны хэлтсийн ажилчин, албан хаагчид, тооцооны кассынхан СХ-ийн хамт олон болохоор нэг жилийн хугацаатай үүрэг авч, бүх ард түмний социалист уралдааны өрнөлтийн жилд социалист ёсоор хамтран ажиллаж, амьдарч, сурч соёлжихоор ажиллаж байна. Манай хамт олон өөрсдийнхөө өмнө тавигдсан зорилтыг амжилттай биелүүлж, амласан үүрэг, төлөвлөсөн ажлаа биелүүлэхэд, социалист хөдөлмөрийн хөдөлгөөн их нөлөө үзүүлж 1974 оны I дүгээр улирлын төлөвлөгөөт зорилтууд амжилттай биелэгдэв.

Мөн төлөвлөгөөт ажлын гол үзүүлэлт болох кассын орлого, хадгаламж хуримтлуулалтын цэвэр өсөлтийн төлөвлөгөө 0,1—0,7 хувиар давж, хэлтсийн

дүнгээр кассын зарлагыг 5,2 хувиар хэмнэв. ЗХУ-ын Эрхүү мужийн банкны конторын ба Архангай, Өвөрхангай, өөрийн хэлтсийн тэргүүний ажилтай хүмүүсийн туршлагыг үйлчилгээний ажлынхаа зарим төрөлд нэвтрүүлж байна. СХТБ-ын ажил тогтмолжиж, долоо хоног бүр соёл хүмүүжлийн ажлыг тусгай төлөвлөгөөтэйгээр явуулж байна.

Энэ маань бидний ажлын эхлэл, тавин жилийн ойдоо барьсан нэгэн бөлөг билээ.

Одоо манай хамт олон СХ-ийн банкны хэлтэс гэдэг хүндэт алдрыг хүртэх зорилт тавин социалист хөдөлмөрийн гавштайчдын тэргүүний сайчуудын улсын II зөвлөгөөний уриалгыг хэрэгжүүлэхээр идэвхийлэн ажиллаж байна.

Ч. ӨВГӨНХҮҮ



Аймгийн банкны хэлтсийн ерөнхий ня-бо Х. Дамбадаржаа банкны байгууллагад олон жил ажиллаж байгаа бүртгэл тооцооны туршилагатай ажилтны нэг юм. Тэрээр БНМАУ-д үндэсний банк байгуулагдсаны 50 жилийн ойг угтаж өөрийн хариуцсан бүртгэл тооцооны ажилд сайхан амжилт гаргажээ.

ЗУРАГ ДЭЭР: Ерөнхий ня-бо Дамбадаржаа тооцоолон бодох машин дээр ажиллаж байгаа нь:

Харилцан суутгах тооцоололт

Нам, засгаас улс хоршооллын байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалт, эргэцийг түргэтгэхэд төлбөр тооцоог боловсронгуй болгох талаар чухал зорилт тавьж байна.

Үүний дагуу улсын банкнаас урьд мөрдөж байсан бэлэн бус тооцооны зааврыг өөрчлөн баримтын эргэцлийг түргэтгэх, акцептлах хугацааг богиносгож дараа акцептлах журмыг нэвтрүүлсний дээр төлбөрийн сахилга батыг сайжруулахад эдийн засгийн хөшүүрэг болгон хугацаа хэтэрсэн инкассын торгуулийн хэмжээг өсгөж төлбөрийн дүнгийн 50 хувь хүртэл хэмжээгээр тогтоосон нь зохих ач холбогдлоо өгч байна.

Мөн улсын хэмжээгээр харилцан суутгах тооцоог үйлдвэр, ХАА-н байгууллагуудад жилд 2 удаа явуулж байхаар шийдвэрлэсэн билээ.

1973 оны жилийн эцсийн тайлангаар үйлдвэр аж ахуйн газруудын хоорондын тооцоогоор гарсан өр, авлагыг барагдуулахаар хийгдсэн нэг удаагийн суутган тооцоолтоор 70 шахам байгууллагын 16,7 сая төгрөгийн өр, авлагыг барагдуулан эргэлтэнд оруулсан юм.

Энэ удаагийн суутган тооцоолтонд аймгийн ХБУ газар, ХАА-н зарим нэгдлүүд идэвхтэй оролцсон байна.

ХҮҮХДИЙН төлөө фондонд

Аймгийн банкны ажилтан, ажилчид их ойгоо угтаж, хүүхдийн төлөө фондонд хувь нэмрээ оруулахын тулд ажлынхаа бус цагаар суббогчид хийж ломбоны тугалга долоон мянга шахамыг хийж, долоон зуу гаруй төгрөгийн хуримтлалыг хүүхдийн төлөө фондонд оруулжээ.

Манай сурвалжлагч

КАССЫНХАНЫ АМЖИЛТ

БНМАУ-д үндэсний банк байгуулагдсаны хагас зуун жилийн ой угтаж тус аймгийн сум-нэгдэл, САА-н банкны тооцооны кассууд орлогын төлөвлөгөөгөө амжилттай биелүүлж байна.

Батсүмбэр, Эрдэнэсант сумын тооцооны касс 5 дугаар сарын орлогын төлөвлөгөөг 100,0—101,2 хувь, хагас жилийн хадгаламжийн төлөвлөгөөг 112,3 хувь, бусад ажлын төлөвлөгөөг 100,0 хувь тус тус биелүүлэв.

ЯЛГАВАРТ ЗЭЭЛЛЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Аж ахуйн тооцоог тууштай нэвтрүүлэн бэхжүүлж нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд банкны зээл, түүний хяналт чухал үүрэгтэй.

Улсын банкны байгууллага зээл хэрэглэгч бүх байгууллагуудын улирал, жилийн балансад судалгаа хийж бүтээгдэхүүний борлуулалт, ашгийн төлөвлөгөөний биелэлт, эргэлтийн хөрөнгийн ашиглалт, түүний бүрэн бүтэн байдал зэрэг үндсэн үзүүлэлтүүдээр сайн, муу, ердийн ажиллагаатай гэж ялгаварлан зээллэгжүүлнэ.

Төлөвлөгөөт үзүүлэлтийг давуулан биелүүлж эргэлтийн хөрөнгийг зориулалтаар нь зөв ашигласан үйлдвэр аж ахуй, худалдааны байгууллагыг сайн ажиллагаатайг тооцож худалдан авагчийн буруугаас борлуулалтын орлого саатвал зээлийн хугацааг сунгах, цалин, хөдөлмөрийн хөлсөнд орлогыг харгалзахгүй зээллэгжүүлэх, нормативаас

хэтэрч нөөцлөгдсөн чухал шаардлагатай бараа материал, түүний эзлэл тур хугацааны зээл олгох, олгосон зээлийн хүүг 50 хувь хүртэл хөнгөлж шагнааг болгон буцаан олгож, тэргүүний ажилтай ажилчдыг сарын цалингийн фондын 5 хувь хүртэл, удирдах ажилтан, ахлах ня-бо нарыг сарын цалингийн 50 хувиар шагнах зэрэг хөнгөлөлт үзүүлж байна.

Төлөвлөгөөт даалгаврыг биелүүлэхгүй алдагдлын хөрөнгийг буруу ашиглаж дутагдуулсан болон өр авлага нэмэгдүүлсэн байгууллагыг муу ажиллагаатай гэж үзэж өөрийн ажиллагаанд байгаа дутагдлыг засах хүртэл зээл олгохыг зогсоох, зориулалт бусаар ашигласан эргэлтийн хөрөнгийг нөхөх, өр авлагыг багасгах хүртэл өндөр хүүтэй зээл олгож санхүүгийн ажиллагааны хяналттай тусгай журамд оруулна.

Хэрэв 6 сарын дотор аж

ахуй санхүүгийн дутагдлаа засаж чадаагүй бол төлбөрийн чадваргүй гэж нийтэд зарлаж, зээлийг хугацаа харгалзахгүй төлүүлэх, бэлтгэн нийлүүлэх чээс бараа материал худалдан авахыг хориглох зэрэг арга хэмжээ авч шаардлага тавина.

Манай аймгийн үйлдвэр аж ахуй, худалдааны байгууллагуудаас 1973 онд санхүүгийн үйл ажиллагаагаар сайн ажиллагаатай байгууллагын болзол хангасан Тээврийн удирдах газар, Барилга угсралтын контор, Өндөрширээт, Батсүмбэр сумын ХБ-ийн ангиудад хөнгөлттэй зээл олгож 12,8 мянган төгрөгийн шагнааг олгосон юм.

Үйлдвэр аж ахуйн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн байдалд явуулж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эдийн засгийн талаас нь удирдах, зохицуулахад эдийн засагчид, санхүүгийн ажилтнууд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Д. ХОРЛОО



Тус аймгийн банкны хэлтэст барилга хөрөнгийн өр оруулалтын ажил эрхэлсэн инженерээр Н. Пунцаг ажилладаг. Н. Пунцаг банкны байгууллагад 10 гаруй жил ажиллаж байгаа бадлагаатай ажилтны нэг бөгөөд тэрээр БНМАУ-д үндэсний банк байгуулагдсаны 50 жилийн ой угтаж хөрөнгөө оруулалтаар санхүүжигдсэн барилгын зураг төслийг хэмжээг шалгах ажлын төлөвлөгөөг амжилттай биелүүлжээ. ЗУРАГ ДЭЭР: Н. Пунцаг ажил дээрээ.

Л. ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг

ХАА-н нэгдлийн зээлийн шинэ систем

ХАА-н нэгдлийн үйлдвэрлэл борлуулалтын ажиллагааг жигд байлгахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрээр тасралтгүй хангах боломжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн төлөвлөлт, бүртгэл, тайлан тооцооны ажилд улсын банкнаас зээллэг, тооцоогоор дамжуулан тавих хяналтыг сайжруулах зорилгоор 1970 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор ХАА-н нэгдлийн

үйлдвэрлэлийн төлөвлөгөөт бүх зардлыг санхүүжүүлэхэд зориулж, түүний төлөвлөгөөт хэмжээнд багтаан богино хугацаат зээллэг олгож, уг зээлийг нэгдлийн нийт мөнгөн орлогоос төлүүлж байх журмыг шинэчилсэн систем болгон хэрэглэх болсон билээ.

Энэ системийг хэрэглэж эхэлснээр нэгдэлд улсаас олгох зээлийн хэмжээ нэгдлийн төлөвлөгөөт

зардлын хэмжээнд хүртэл өргөжих болсон нь улсын банкны богино хугацаатай зээллэгийн давуу талыг харуулж байна.

Үүний үр дүнд нэгдлийн мөнгөн орлогын төлөвлөгөөний биелэлт, түүний зарцуулалтанд тавих хяналт эрс сайжирлаа.

ХАА-н нэгдэлд олгож байгаа урт, богино хугацаатай зээллэг нь нэгдлийн материал техникийн баазыг бэхжүүлэн, үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэхэд чиглэгддэг.

Тус аймгийн нэгдлүү-

дийн авсан урт ба богино хугацаатай зээллээс зохих болзлын дагуу 13 орчим сая төгрөгийг хугацааг сунгасан ба зээлийн төлбөрөөс чөлөөлж хөнгөлөлт үзүүлсэн юм.

Зээлийн шинэ системийг өөрийн аймгийн ХАА-н нэгдлийн үйлдвэрлэлийн ажиллагаанд нэвтрүүлснээр үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний зохиолт сайжирч, эргэлтийн хөрөнгийн ашиглалт дээшлэн, өр авлага гарах явдал багасан, зээлийн эргэлт түргэсэв.



Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

Танхайрал бол хүний зан төрх, хүмүүжлийн хоцрогдлоор илэрдэг ёс суртахууны харш үзэгдэл юм.

«Олны дунд үгээ, ганцаар явахдаа сэтгэлээ шинж» гэсэн сургаамж бол олон нийтийн дунд биеэ зөв авч явсан бусдыг хүндэтгэн үзэж ирсэн ёс суртахууны уламжлалт сайхан заншлын илрэл мөн.

Иймээс танхайрлын гэм буруу үйлдлийг хөнгөн жижиг зөрчил, эрүүгийн гэмт хэрэг гэж зааглан захиргааны буюу эрүүгийн шийтгэл хүлээлгэдэг журамтай. Харин танхайрсан хөнгөн жижиг зөрчлийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүдэлчдийн 1974 онг 111 дүгээр зарлигт заасан үйлдлээр ангилан үзэж захиргааны журмаар шийдвэрлэдэг юм.

Энэ зарлигт заасан зөрчлийн заримаас дурдвал: Олон нийтийн газар хэрүүл маргаан үүсгэх, бусдыг өдөөн хатгах, айлган сүрдүүлэх, цээртэй үгээр хараах, үйлчилгээ-

ний газрын журмыг гажуудуулах, дарааллын журам зөрчих, байр орон сууцанд бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, барилга байгууламж, гудамж талбайн зүлэг, модыг гэмтээх, бохирдуулах зэрэг үйлдлүүд хамаарагдана.

Дээрх танхайрлыг гэмт хэргийн шинжтэй бол БНМАУ-ын эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлд заасан үйлдлийн хэлбэр, хор уршгийн байдлаар доорхи гурван хэсэгт ангилж, нийтийг илтэд хүндэтгэн үзээгүй, нийтийн хэв ёс, хамтын аж байдлын хэв журмыг санаатай зөрчсөн гэмт үйлдэл гэж хамаардаг болжээ.

Харин уг хэргийг хүч хэрэглэсэн буюу засгийн төлөөлөгч, хэв журмыг сахиулж байгаа хүнийг эсэргүүцсэн, эсхүл онц жигшүүртэй дүрсгүйтэж догшин авирдсан юмуу урьд танхайрсан хэрэгт шийтгэгдсэн этгээд үйлдсэн бол хүндрүүлэх шалтгаантайд тооцогдоно.

Танхайрлын үйлдлийг хөнгөн жижиг зөрчлөөс

ялгах эрүүгийн гэмт хэргийн шинж нь: олны дунд буюу олон нийтийн амгалан тайван байдал тогтоосон дэг журам, эсхүл хамтын аж байдлын нөхцөлийг алдагдуулан түүний эсрэг чиглэсэн ноцтой хор хохирол бүхий санаатай үйлдэл байдаг оршино.

Танхайрлын гэмт хэргийн үүсэн гарах шалтаг, ихэвчлэн давьтаргүй хүнд хирээс хэтэрсэн согтуурал сүрхий нөлөөлж угаас хүмүүжлийн төлөв-

гуулалт, суртал ухуулга, хүмүүжлийн олон талтай ажлыг үр нөлөөтэй арга хэлбэрээр байнга зохиож байх нь чухал юм.

Социалист нийгмийн гишүүний алдар хүндтэй ариун сайхан нэр төрөө эрхэмлэн өндөрт өргөж явахын тулд хувийн хариуцлага, учраа мэдсэн сахилга бат, ёс суртахууны зөв боловсон хүмүүжлийг бие дааж эзэмших зүй ёсны шаардлага таамагдаж байна.

Гэтэл сүүлийн үед хэт

царай дарж, хүнийг улам үхээц дорой мэт харагдуулахаар барахгүй танхай тэрсүү этгээд болгон дүрсэлж байдаг ажээ.

Ах зах хүний үг сургамжийг үл тоомсорлох, бүдүүлэг үг хараал хэлэх, биеэ тоож мэдэмгийрхэж сагсуурах явдал бол бас л танхай хүний араншин мөн.

Зөвлөлт Холбоот Улсын яруу найрагч, Лениний шагналт РАСУЛ ГАМЗАТОВ «... одоо үед залуусын толгойг эргүүлэх хандлагатай гол гурван хор байна.

Үүний нэг, хоёр дахь нь ТАНХАЙРАЛ, ХӨЛЦҮҮРЭЛ гурав дахь нь ХЭРГЭМ ЗЭРЭГ ГОРИЛОХ... явдал юм гэж хэлсэн байна.

Энэ бүхнийг анхааран хууль эрхийн мэдлэг хүмүүжлээ дээшлүүлэхийн төлөө хүн нэг бүр санаачилга чармайлт тавьж, өөрийн залуу үеэ хуучин нийгмийн элдэв хоцрогдол, гэмт хэрэгт өртөгдөж болзошгүй осол эндэгдлээс хамгаалж, шударга сайн иргэний зэрэгт хүргэхийн төлөө бүх нийтээр тэмцэл тавьж ажиллах нь чухал байна. Х.БАЛЖИННЯМ

ТАНХАЙРЛЫН ГЭМТ ХЭРЭГ

шил муутай дээр нь улам нэмэрлэж, түүний мэдэргэлийн тэнцвэрийг алдагдуулан эцсийн дүнд гэмшил, зэмлэлд оруулах тохиолдол цөөнгүй байна.

Тус аймагт эрүүгийн гэмт хэргийн гаралт жилдээ жилд харьцангуй баар багасч байгаа боловч хэв журмын зөрчил 1973 онд урьд оноос өсч уг хэргийн 87 хувь нь ууж согтуурснаас үүсэн гарч байжээ.

Ийм учраас танхайрлын хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион бай-

цамирхсан хувцас хунар өмсөж, үс гээгээ марзан этгээд болгож яваа тохигүй хүмүүс бий болсоор байна. Тэдний сонгож дууриасан маяглал нь монгол хүний шударга да-руу сайхан чанар, уламжлалт ёс заншлыг гутаахад хүргэж байгаа юм.

Гээгээ залгай унжуулж явах, гутлын түрий шамлаж нугалахыг эрт дээдсийн үед үй гашуудлын тэмдэг болгож байсныг бодолцоход илүүдэхгүй биз. Чих, шилээ давуулж ургуулсан халимаг зүс

Мэргэжилтний зөвлөлгөө

ЦЭНЭГ УСАЛГАА

Хөдөө аж ахуйн тариалалт ургамлын талбайд цэнэг усалгаа их ач холбогдолтой юм.

Ялангуяа төмс, хүнсний ногоо, амуу тарианы ургамлуудыг тарих талбайд намар, хаварт цэнэг усалгааны ажлыг агро-техник-ийн бусад арга хэмжээтэй хослуулан хийж шаард-дагдах усыг өгч чадсанаар та тутмаас авах ургамлыг нэмэгдүүлэх тариалсны дараах усалгааны ажилла-гааг хөнгөвчлөхөд ашигтай юм.

Цэнэг усалгаагүйгээр зөвхөн ургалтын үеийн усалгааг хийхэд дээрээс өгч буй ус нь дороос холбогдох хөрсний усны нөөцгүй болох учир ургамалд онц нөлөөлөхгүйгээр эргэж уурих буюу эсвэл нэг удаагийн усал-таар 1 га-д өгөх усны хэмжээг ихэсгэх шаард-лагатай болдог. Ус цаг уурын олон жилийн су-далгааны материалаас үзэхэд Орхон, Сэлэнгийн сав газрын хөндийнүүдэд дулааны улиралд унадаг тунадасны 80 орчим хувь нь 7 дугаар сарын сүүлч 8 дугаар сард унадаг байна.

Ийм учраас 5, 6, 7 ду-гаар сарын эхний 10 хо-ногт чийг ихээхэн дутаг-даг. Ус чийг ихээхэн шаарддаг байцаа зэрэг ургамлуудад тунадас эл-бэгтэй саруудад ч гэсэн

нэмэлт усалгаа шаардла-тай байна.

Туршлагаас үзэхэд нам-рын цэнэг усалгаа нь амуу тарианы ургамлуудад онц ашигтайн дээр урт үндэстэй, хавар эрт таригддаг ХАА-н бусад ургамлуудад нэгэн адил ашигтай бөгөөд хортон шавьжны ангилалд мэ-рэгч амьтадыг устгаж хо-гийн ургамлуудын үрийг үхүүлж багасгад-гийн зэрэгцээ хаврын та-риалалтын хугацааг 10 орчим хоногоор урагш-дуулдаг сайн талтай.

Намрын цэнэг усалгааг цэвэрлэж хагалгааны да-раа хийж өгөх нь хам-гийн ашигтай бөгөөд дунджаар га-д 500 ам-дөрвөлжин метрээс доош-гүй ус өгөхөөр бодож ус-алтыг хийнэ.

Хавар орой таригддаг хүнсний зарим ногоонд хаврын цэнэг усалгаа илүү ашигтай.

Тэгэхдээ усалгаа нь тарих хугацаанд хэдий чинээ ойр байвал төдий-чинээ с а й н, шавран-нар хүнд хөрсөнд үр суулгахаас 5-7 хоногийн өмнө, хөнгөн элсэнцэр хөрсөнд 4-5 хоногийн өмнө усалтыг хийх нь ашигтай.

Цэнэг усалгаа нь хөрс-ний температурын горимд ихээхэн нөлөөлдөг.

Хавар эрт их нормоор га-д 600-800 кубметр цэнэг усалгаа хийгдсэн

хөрс нь усалгаа хийгдээ-гүй хөрснийг бодвол 1 метрийн гүнд барагцаа-гаар 10 хоногийн өмнө гэсдэг байна.

Намар, хаврын цэнэг усалгааг хийхдээ тухайн үед унасан тунадасны хэмжээнээс хамааруулан хугацаа ба нормын тохи-руулна.

Нэг удаа 5 мм-ээс дээш унасан тунадасыг ашигтай гэж үзэх бөгөөд түүний 50 хувь орчим нь хөрсөнд шингэж ургам-луудад ашиглагддаг бай-на. Унасан тунадасны 1 мм нь нэг га-д 10 куб-метр ус өгсөнтэй тэнц-нэ.

С.ГОМБОСҮРЭН

Тракторын 30 мэргэжил

Ленинградын Кировын заводын дамжлагаас ши-нэ хийцийн К-70 гэдэг трактор гарав. Шинэ трактор 300 морини, өө-рөөр хэлбэл өмнөх К-700 трактороос 80 морини-хоор илүү хүчтэй. Хийж байгаа ажлын шинжчана-раас шалтгаалан бүтээмж нь 25-40 хувиар илүү.

Шинэ хийцийн энэ тра-кторыг янз бүрийн ажилд хэрэглэж болно. Нэмэлт багаж, агрегат угсраад түүнийг 30 гаруй мэргэ-лийн ажилд буюу хамагч, цас цэвэрлэгч, ачаа а-чигч, буулгагч, овоо-логч болгон хэрэглэж болно.

(АПН)

Шүүмжлэгдсэний дараа

Малын зүй бусын хорогдол багаслаа

Тус сонины энэ оны 4 дүгээр сарын 26 дугаарт манай сумын малын зүй бусын хорогдол өнгөрсөн жилийн мөн үеийнхээс их байгаа, мөн эмчилгээ, тэжээлийн цэгийн тохи-жилт, эмчилгээ, тэжээл-лэгийн арга хэмжээ хан-галтгүй байгааг шүүмжлэ-сэн билээ.

Үүний дагуу сумын на-мын хорооны товчоо, АДХ-ын гүйцэтгэх захир-гааны гишүүд, сумын ма-лын хорогдолтой тэмцэх комиссын хамтарсан зөв-лөлтөөн хийж цаашид ма-лын зүй бусын хорогд-лыг таслан зогсоох, ба-мын хорооны нарийн бич-гасгах арга хэмжээнүү-дийг боловсруулж, өвч-

тэй малын байрыг ду-лааж, тохижуулан, хү-рэлцэх хэмжээний тэ-жээл татаж, усны зөөв-рийг тохижуулан эм та-рилгуудаар хангаж, өвч-тэй малд өвчний түүх, ам-булаторийн журнал хөт-лүүлсэн юм.

Мөн их эмчийн үзлэ-гийг 7 хоногт 1 удаа хийлгэхийн хамт сууриу-лаас өвчтэй мал цуглуу-лах ажлыг 7-14 хоногт 1 удаа зохиож байгаа-гийн үр дүнд малын зүй бус хорогдол өнгөрсөн саруудынхаас 4 дүгээр сард 30 хувиар багаслаа гэж Баянзүрх сумын на-мын хорооны нарийн бич-гийн дарга Л.Чинэд ма-найд хариу мэдэгдэв.



ТАЙЛБАРЛАЛТГҮЙ.

О.СУМЬЯА-гийн зурсан зураг

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ